

Сайн чанарын дулаалгын материал яагаад хэрэглэх хэрэгтэй вэ?

Хүн амьдралынхаа 70-80 хувийг ямар нэг барилга байгууламж дотор өнгөрөөдөг. Энэ утгаараа таны ажиллаж, амьдарч буй барилгууд хүйтэнд дулаан, халуунд сэрүүхэн, тав тухтай, галын аюулгүйн байдал бүрэн хангасан, дуу чимээгүй, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй материалаар баригдсан байх нь чухал юм.

Сүүлийн үед янз бүрийн шийдэлтэй дизайн бүхий барилгууд ихээхэн баригдах болсон. Үүнийг дагаад барилгуудад ашиглах дулаалгын материал нь уян хатан хөвөнлөг байх шаардлага улам бүр нэмэгдсээр байна. Эрдэс чулуун хөвөн нь ямар ч хэлбэртэй гадаргууг дулаалж болохоос гадна дулаалгын материал хоорондын зай, засвар багасаж, заадас хоорондын зайгаар дулаан алдахыг зогсооно. Нэгэнтээ барьсан барилгын дулаалгыг ойр ойрхон солих нь зардал ихтэй, их цаг хугацаа зарцуулсан ажил болдог учир дулаалгын материал нь барилгатайгаа адил хэмжээний удаан эдэлгээ, насжилттай байх хэрэгтэй.

Өндөр, олон давхар барилгуудад гал гарахад түүнийг унтраах маш хүндрэлтэй байдаг. Тэгвэл галын эх үүсвэрийг өдөөж дэмждэггүй эрдэс чулуун хөвөн дулаалгын материал ашигласнаар галыг даамжруулахгүй зогсоож чадна. Ингэснээр хүний амь нас, эд хөрөнгийг хамгаалах тул галд тэсвэртэй дулаалгын материалыг хэрэглэх нь зөв сонголт юм.

Инноваци шингэсэн шилдэг тусгаарлагч.
Монгол инженерүүдийн бүтээсэн дэлхийн чанар.



QR кодыг уншуулж
үнийн санал татаж авна уу.



ХАЯГ:

Үйлдвэр

Баянгол дүүрэг, Үйлдвэрлэлийн
баруун бүс - 132
Улаанбаатар хот, Монгол улс
Утас: +(976)-75114444
Факс: +(976)-70170208
И-мэйл: monbasalt@rockwool.mn

www.basaltwool.mn

[Mongol Basalt JSC](#)

[@Mongol_Basalt](#)

[Mongol_Basalt](#)

 **BASALTWOOL®**
МОНГОЛ БАЗАЛТ ХК

БАЗАЛИТ FLEX



Basaltwool

Basaltwool эрдэст чулуун хөвөн нь аж үйлдвэр, уул уурхай, эрчим хүч, барилга, орон сууцны дулаан тусгаарлагч материалын бүхий л зах зээлд хэрэглэнэ. Эрдэст чулуун хөвөн дулаан тусгаарлагч нь галд сайн тэсвэртэй 1100°C градуст шатдаггүй (барилгын гал түймрийн хөмгийн оргил температур 960°C), дулаан тусгаарлах чадвар хамгийн өндөр (дулааны зардлыг 90 хүртэл хувиар бууруулдаг), дуу тусгаарлах чадвар хамгийн сайн, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй (Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагаар баталгаажсан), ус чийг нэвтрэдэггүй (физик шинж чанар нь усыг дотогш нэвтрүүлдэггүй), уян хатан зэрэг давуу чанартай. Бусад дулаалгын материалуудаас илт давуу, технологийн өндөр инновациар бүтээгдсэн шилдэг бүтээгдэхүүн юм.


Базалит Flex

Амины орон сууц, зуслангийн байшин, Канад хаус зэрэг байшингуудын хана, тааз, дээвэр шалны дулаан тусгаарлагч.



Уян хатан

Деформацид ордоггүй учир ямар ч гадаргууд байрлуулсан эргээд тэлж хавтан хоорондох зай маш бага болдог ба үүний хэрээр дулаан тусгаарлалт нэмэгддэг.



ГАЛД ШАТДАГГҮЙ

-180°C+1100°C температурыг тэсвэрлэх тул галын эрсдэлээс бүрэн хамгаална.



ХАЛУУН БОЛОН ХҮЙТНЭЭС ТУСГААРЛАНА

Дулаан дамжуулах коэффициент $\lambda=0.036$ Вт/мК.



УС, ЧИЙГ ШИНГЭЭХГҮЙ

Усны уурын тархалтыг тэсвэрлэх коэффициент $\mu=1$ буюу агаарынхтай тэнцүү.



ДУУ ЧИМЭЭГ ШИНГЭЭЖ ТУСГААРЛАНА

Базалт чулуун хөвөнгийн мяндаслаг, хөвөнлөг чанар нь дуу чимээг тусгаарлах чадварыг эрс нэмэгдүүлж байдаг. 45ДБ-аас дээш тусгаарлана.



ГАЖИЛТАНД ТОГТВОРТОЙ

90%-ийн харьцангуй чийгшил ба +700°C-ийн температур дахь өөрчлөлт 1%-иас хэтрэхгүй.



УРТ УДААН ЭДЭЛГЭЭ, ҮНЭ ЦЭНИЙН БАТАЛГАА

65 жилээс дээш эдэлгээтэй, ашиглалтын зардал хамгийн бага, хөрөнгө оруулалтын үнэ цэнийг жил бүр өсгөх баталгаатай.



БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ЭКО

Дэлхийн хэмжээнд нийт эрчим хүчний 47%-ийг барилга байгууламж халаах, хөргөхөд зарцуулдаг бөгөөд байгалийн цэвэр чулуун хөвөн дулаалгын материал нь эрчим хүч, дулааны хэрэглээг бууруулж нүүрс хүчлийн (CO₂) хийг багасгана.



Дуу чимээ тусгаарлалт /Акустик/

Эрдэст чулуун хөвөнгийн мяндаслаг, хөвөнлөг чанар нь дуу чимээг тусгаарлах чадварыг нь эрс нэмэгдүүлж байдаг. Хамгийн сайн чанарын дуу тусгаарлагч юм.



Халуун болон хүйтэн тусгаарлалт

Барилга гадна ханаараа 37 хувийн дулаанаа алддаг. Тиймд гадна хананы дулаалгын зузааныг хамгийн багадаа 15 см тооцох хэрэгтэй.

Өрөө хоорондын ханын дулаалга нь дуу чимээ тусгаарлахаас гадна өрөө болгоныг тохирсон дулааны хэмтэй тохируулах боломж өгнө.

